

БНМАУ-ЫН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН
ХОРОО, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙ-
ЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН ХУРЛЫН
ТОГТООЛ

1987 оны 2 дугаар
сарын 18 ны өдөр

Дугаар 23/41

Улаанбаатар
хот

Хороо ажиллуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 323 дугаар тогтоол болон БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооны 1986 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн БНМАУ-ын Биеийн тамир, спортын улсын хороо, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

Хотын АДХ-г 1988 114/305
1. Ажилчны районд Биеийн тамир, спортын хороог 1987 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн ажиллуулсугай.

2. Тус районы хөдөлмөрчид, үйлдвэр, албан байгууллагын дунд зохиогдох нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг Хөдөлмөр нийгэмлэгээс эрхлэн явуулах боломжтойг үндэслэн Ажилчны районы Биеийн тамир, спортын хорооны даргын үүрэгт ажлыг Хөдөлмөр нийгэмлэгийн даргад давхар хариуцуулан, районы Биеийн тамир, спортын хорооны зааварлагч-арга зүйч нэгийг ажиллуулахыг Биеийн тамир, спортын хороо /н.Содномзундуй/-нд, орон тоо, цалингийн фондыг бүртгэж, жил бүр Биеийн тамир, спортын арга хэмжээний зардлыг нь батлан өгч байхыг Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т тус тус даалгасугай.



БНМАУ-ЫН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ДАШДӨВДОН



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

102

АЖИЛЧНЫ РАЙОНД БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХОРОО АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА

1987 оны 2 дугаар
сарын 5-ны өдөр

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай- 323 дугаар тогтоолд ... "Аймаг, хот, районд биеийн тамир, спортын хороо ажиллана. Тус хороо нь тухайн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаа, Биеийн тамир, спортын улсын хороонд захирагдана" гэсэн заалтыг үндэслэн нийслэл хотын Сүхбаатар Октябь, Найрамдал, Налайх, Багануурын районд биеийн тамир спортын хороодыг байгуулж орон тоо, цалингийн фондыг хэмнэх үндсэн дээр Хөнгөн хүнсний үйлдвэрийн яамны "Хөдөлмөр" нийгэмлэгт Ажилчны районы биеийн тамир, спортын үүрэгт ажлыг 1987 оны 2 дугаар сар хүртэл хавсран гүйцэтгүүлсээр ирсэн юм.

Одоо Ажилчны районд үйлдвэр, аж ахуй, соёл үйлчилгээний 100 гаруй байгууллага, 60 гаруй мянган хөдөлмөрчид, 31,8 мянган ажиллагсад, ерөнхий боловсролын 13, техник мэргэжлийн сургууль, техникум, дээд сургууль 6 ажиллаж 20 гаруй мянган оюутан сурагчид хамрагдан суралцаж, тус районы үйлдвэр, албан байгууллагын тоо олширч, оршин суугчдын хүрээ өргөжиж тэдний дунд зохиогдох нийтийн биеийн тамир, спортын ажлын цар хүрээ ихэсч "Хөдөлмөр" нийгэмлэгээс зохиох ажлын ачаалал нэмэгдэн хүндрэл гарч байна.

Ийм учраас "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээнй тухай" МАХН-ын Төв Хорооны 1979 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тогтоолын I дүгээр заалтанд "... Тус оронд биеийн тамир, спортыг хөгжүүлэх ажлыг төрөөс удирдах удирдлагыг хүчтэй болгох, хөдөлмөрчдийн коммунист хүмүүжил, түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох бие бялдрын хүмүүжлийн ажлыг эрхлэх үүрэг бүхий улс, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг улам нэгтгэн уялдуулж байхын тулд ... Алдар, Хүч, Хөдөлмөр нийгэмлэгээс бусад нийгэмлэгийг аймаг, хот, районы биеийн тамир, спортын хороо болгон өөрчилж, түүнд спорт клуб хамтлаг байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй" гэсэн заалтыг үндэслэн Ажилчны районд Биеийн тамир, спортын хороо ажиллуулах саналыг боловсруулж БНМАУ-ын Биеийн тамир, спортын улсын хороо, Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захир-

гаанд оруулж байна.

Ажилчны районд биеийн тамир, спортын хороог ажиллуулснаар районы дэвсгэрийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, биеийн тамир, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгон өрнүүлж, хүн амыг бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй болгох өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэх, биеийн тамир, спортын ажлыг шинжлэх ухаан-арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, спортын арга хэмжээг зохион байгуулахад мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, тэдний хүчийг зохион байгуулах ажлыг эрхлэн гүйцэтгэх юм.

Районы биеийн тамир, спортын хорооны орон тоог Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооны 1986 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 263 дугаар тогтоолыг үндэслэн ажиллуулах болно.

Районы биеийн тамир, спортын хорооны даргыг Хөдөлмөр нийгэмлэгийн даргад давхар хариуцуулан зааварлагч-арга зүйч нэгийг ажиллуулж цалин, арга хэмжээний зардлыг районы Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанаас санхүүжүүлэх юм.

УЛААНБААТАР ХОТЫН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРОО